



Герман улсын туршлага

- Герман улс органик тариалангийн 100 жилийн түүхтэй.
- Органик тариалан анх нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн хөдөлгөөний хэлбэрээр үүсэж, улмаар бодлогын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн.
- Органик тариалангийн мэргэжлийн холбоод 18 мянган гишүүдтэй, бодлогын нөлөөлөл үзүүлэх чадавхтай.
- Органик бүтээгдэхүүний “эко”, “био” гэсэн тодотголүүдыг Европын Холбооны түвшинд патентжуулсан.
- ЕХ-ны Органик хүнсний тухай суурь журам анх 1991 онд батлагдаж, одоо 2018/848 тоот шинэчилсэн хувилбараар мөрдөгдөж байна.
- ЕХ-ны журмын хэрэгжилтийг гишүүн орнууд дотооддоо зохицуулдаг. Герман улс: Органик тариалангийн тухай хууль.
- Органик тариалангийн зөвлөх үйлчилгээнд Хөдөөг хөгжүүлэх Европын ХАА-н сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.
- Зөвлөх үйлчилгээний, бүтэц зохион байгуулалт, бодлогын дэмжлэг муж улс бүрт өөр.
- Муж улс бүрт Органик тариалангийн сургалт, мэдээллийн төвүүд төрөл бүрийн чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Органик тариаланг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг, сургалт, зөвлөх үйлчилгээ – Хүнсний ногооны салбарын жишээ

Герман улсад 2022 оны байдлаар нийт ХАА-н үйлдвэрлэгчдийн 14 хувь болох 37 мянган тариаланчид органик газар тариалан болон зөгийн аж ахуй эрхэлж байна. 18 мянган тариаланчид органик тариалангийн аль нэг мэргэжлийн холбоонд харъяалагддаг. Органик тариаланд Герман улсын нийт тариалангийн газрын 11 хувь ногдож буй бөгөөд 16 муж улс, муж улсын статустай хотуудад уг хувь хэмжээ харилцан адилгүй, тухайлбал Нийдерзаксен, Нордрин-Вестфален муж улсуудад 6 хувь, харин Бременд 34 хувь байна.

Статистикийн хувьд органик тариалан эрхэлдэг нэг аж ахуй тутамд органик бүтээгдэхүүн боловсруулдаг 0.6 ширхэг ААН ногддог. Органик тариаланчдын адилаар органик хүнс үйлдвэрлэгчид ч мөн Европын Холбооны (ЕХ) холбогдох дүрэм, журмуудыг мөрдөнө. Төрөөс итгэмжилсэн хувийн хэвшлийн хяналтын байгууллагууд эдгээр ААН-үүдэд тогтмол хяналт тавьж ажилладаг.

Органик тариалан нь газар тариалангийн тогтвортой хөгжлийн чухал чиглэлд тооцогддог тул органик тариалангийн цар хүрээг өргөжүүлэх бодлогын зорилтуудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал 2030 он хүртэл нийт тариалангийн газарт органик тариалангийн талбайн эзлэх хувийг Европын Холбооны түвшинд 25 хувь, Герман улсын түвшинд 30 хувь, Нийдерзаксен муж улсын түвшинд 15 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн. ЕХ-ноос ХАА-н хамтын бодлого (GAP)-ын хүрээнд органик тариаланд дэмжлэг үзүүлдэг бөгөөд дэмжлэгийг хэрхэн тариаланчдад хүргэхийг ЕХ-ны гишүүн орнууд өөрсдөө шийддэг. Герман улсад бол органик тариаланд дэмжлэг үзүүлэх асуудлыг муж улс тус бүрт тухайн муж улсын захиргааны санал, шийдвэрт үндэслэн зохицуулдаг.

Төсөл хэрэгжүүлэгчид



International

Герман улсын органик хүнсний ногооны үйлдвэрлэл

Герман улсын органик хүнсний ногоо үйлдвэрлэгчдийг ногооны аж ахуй ба газар тариалан эрхлэгчид гэж хоёр ангилдаг бөгөөд ногооны аж ахуй эрхлэгчид голчлон нарийн ногоо тариалдаг бол газар тариалан эрхлэгчид голчлон тодорхой нэг таримлаар төрөлжсөн байдаг.

	Ногооны аж ахуй эрхлэгчид	Газар тариалан эрхлэгчид
Таримлын төрөл	Нарийн ногоо	Ил талбайн хүнсний ногоо
Тариалангийн онцлог	Эрчимжсэн, олон төрлийн хүнсний ногоо	Цөөн таримлаар төрөлжсөн
	Жижиг талбай, өндөр ургацтай	Том талбайгаас ургац авдаг
	Гар ажиллагаа зонхилсон	Механикжсан
Талбайн хэмжээ	0.5-с цөөн га хүртэл	Олон зуун га хүртэл
Байршил	Ихэвчлэн хотын ойролцоо	Үржил шим сайтай хөрстэй газар
Борлуулалтын үндсэн сувгууд	Аж ахуй дахь дэлгүүр, хүнсний ногооны захууд, хүргэлтийн үйлчилгээ	Том худалдан авагчид, Борлуулалтын нэгдлүүд, боловсруулах үйлдвэрүүд



Ковид цар тахлын үед гэртээ тусгаарлагдсан иргэдийн органик хүнсний ногооны худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалж 2021 онд Герман улсын органик ногооны тариалан эрс нэмэгдсэн. Ялангуяа газар тариалан эрхлэгчид сэлгээгээ өөрчилж, хүнсний ногоог урьд өмнөхөөсөө илүү ихээр тариалах болжээ.

Эх сурвалж: DESTATIS, Хүнсний ногооны тооллого 2022. Графикийн эх сурвалж: i-KÖN 2023

Топ 10	Герман улсад тариалсан органик ногооны зонхилох зүйлүүд, 2022 онд	Тариалсан талбай (га)
1	Шар лууван	3000
2	Хулуу (Хоккайдо, лийрэн, үлэмж хулуу зэрэг дэд зүйлүүд)	1863
3	Хэрээн нүд	1610
4	Бөөрөнхий сонгино (мөн шалот сонгино)	1560
5	Вандуй (хальстай ба хальсгүй)	1180
6	Хүрэн манжин	994
7	Давжаа шош	657
8	Брокколи	535
9	Бөөрөнхий байцаа (einschl. Spitzkohl)	492
10	Бууцай	435

Эх сурвалж: DESTATIS, Хүнсний ногооны тооллого 2022

Органик шар лууванг 2022 онд Герман улсад 3.000 га талбайд тариалсан нь органик хүнсний ногооны нийт талбайн 17 хувийг эзэлжээ. Дотоодын хангалтын хувь хэмжээ органик шар лууванд 60



хувь, жимслэг органик ногоонд 20 шахам хувь байна. Герман улс органик ногооны дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж хараахан чадаагүй тул импортоос хамааралтай.

Герман улсын органик тариалангийн хөгжил

Органик тариалан Герман улсад 1920 оноос эхлэн үүсэж, хөгжсөн бөгөөд ялангуяа 1970-аад онд ХАА-н аж ахуйн салбарын аж үйлдвэржүүлэх явцад үүний эсрэг хувилбар болгож органик тариалан эрхлэх хандлага дэлгэрчээ. Уг “альтернатив” хэлбэрийн тариалан эрхлэгчид органик тариалангийн мэргэжлийн холбоодыг санаачлан бий болгож, зохион байгуулалтад орсон байна. 1970-аад оны үед эхлээд мөн томоохон хотуудад органик хүнсний дэлгүүр, бөөний худалдааны төвүүд бий болжээ. Органик тариалангийн холбоод эхлээд органик тариалан эрхлэх журам, зааврууд, яваандаа мөн боловсруулах үйлдвэрүүдэд чиглэсэн заавруудыг боловсруулж, мөрдүүлэх болжээ. Герман улсын анхны органик тариаланчид бүгд органик тариалангийн холбоодод гишүүнээр элссэн тул холбоодын зүгээс мөн гишүүддээ чиглэсэн зөвлөх үйлчилгээ эрхэлж эхэлсэн байдаг.

Органик тариалангийн талаарх Европын Холбооны эрх зүйн зохицуулалт

Анх 1991 онд Европын Нийгэмлэг (ЕХ-ны өмнөх байгууллага) Органик хүнсний тухай журам баталсан бөгөөд уг журмыг өнөөг хүртэл хоёр удаа үндсээр нь өөрчилжээ. 2022 оны 1-р сарын 1-нээс эхлэн Органик хүнсний тухай 2018/848 тоот сүүрж журам (EU Öko-Basis-VO 2018/848), уг сүүрж журамд дагалдах журмууд мөрдөгдөж байна. Түүнчлэн органик тариалангийн мэргэжлийн холбоо бүр өөрийн журам, стандарт, заавруудыг боловсруулсан бөгөөд тэдгээрийг гишүүд нь мөрдөх үүрэгтэй. Гэхдээ Герман улсын органик тариалан эрхлэгчдийн талаас илүү хувь нь органик тариалангийн мэргэжлийн холбоодод харъяалагддаггүй бөгөөд эдгээр тариаланчид ЕХ-ны журам, стандартуудыг мөрддөг.

Ургамал хамгаалал, бордоо

Органик тариаланд химийн болон синтетик ургамал хамгааллын бэлдмэл, эрдэс азотын бордоо, генийн өөрчлөлттэй аливаа бэлдмэл хэрэглэхийг хориглодог. Хөрсний үржил шимийг хадгалах, сайжруулахад органик бордоо, ногоон бордуур, буурцагт ургамал бүхий сэлгээ ашигладаг. Органик тариаланд ашиглахыг зөвшөөрсөн бодисуудыг ЕХ-ны 2018/848 тоот журмын (EU-VO 2018/848) хавсралтад зааж өгсөн байдаг. Уг журмын 1-р хавсралтад ургамал хамгааллын бэлдмэлүүдэд агуулагдахыг зөвшөөрсөн үйлчлэх бодисуудыг, 2-р хавсралтад бордоо, хөрс сайжруулагч болон тэжээлийн бодисуудыг жагсаажээ.

Органик тариаланд ашиглахыг зөвшөөрсөн Ургамал хамгааллын бэлдмэл, бордооны

	ЕХ-ны Органик хүнсний тухай журамд зааснаар
Ургамал хамгааллын синтетик бэлдмэл	хориглосон
“Спиносад” (Spinosad) инсектицид	зөвшөөрсөн
Хүхэр, гераниол (Geraniol), парафин тоснууд, тимол (Thymol)	зөвшөөрсөн
Ургамлын гаралтай пиретрин (Pyrethrine)	зөвшөөрсөн
Зэсийн нэгдлүүд	тодорхой нөхцлүүдээр зөвшөөрсөн
Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эрдэс бордоо	хориглосон
Малын үсний нунтаг, ноос, эвэр, түүрайн нунтаг	тодорхой нөхцлүүдээр зөвшөөрсөн
Өтөг	аж үйлдвэрийн маллагаанаас бусад тохиолдолд зөвшөөрсөн
Хүлэр	зөвхөн ногооны аж ахуйд зөвшөөрсөн

Эх сурвалж: Европын холбооны (EU) 2018/848 тоот журам



Органик тариалангийн чадварыг нэгтгэх

Органик тариалангийн эрх зүйн зохицуулалт байгаагүй үед органик хүнсний бүтээгдэхүүнүүдийг органик тариалангийн мэргэжлийн холбоодын логогоор шошголдог, үүнд тухайн холбоодын журам, заавруудыг мөрддөг байв. Хууль, эрх зүйн зохицуулалт бий болсноор зарим тариаланчид мэргэжлийн холбоодод нэгдэхээс татгалзаж, Герман улсын засгийн газраас 2001 онд нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүний шошгыг хэрэглэх болжээ. Уг шошго нь хүнсний болон бусад ХАА-н бүтээгдэхүүнүүд ЕХ-ны Органик хүнсний тухай журамд заасан шаардлагуудыг хангаж буйг илэрхийлдэг. Мэргэжлийн холбоодын гишүүнчлэлгүй органик тариаланчид олшрох тусам органик тариалангийн талаар сургалт, судалгаа, мэдлэг түгээх ажлыг илүү өргөн цар хүрээтэйгээр шинэчлэн зохион байгуулах хэрэгцээ үүссэн бөгөөд уг асуудлыг муж улсууд төрөл бүрийн арга замуудаар зохицуулсан байдаг. Өнөөгийн байдлаар ихэнх муж улсуудад “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” ажиллаж буй боловч эдгээр төвүүд бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хувьд харилцан адилгүй. Тухайлбал Баваарь муж улсын “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” нь тус муж улсын ХАА-н судалгааны төвийн нэг хэлтэс хэлбэрээр ажилладаг бөгөөд органик тариалангийн чиглэлийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, тариалангийн туршилт гүйцэтгэх, органик тариалангийн талаар мэдлэг түгээх, зөвлөх үйлчилгээнд ашиглах гарын авлага, материалуудыг бэлтгэх зэрэг үндсэн чиг үүргүүдтэй. Заксен муж улсын “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” тус муж улсын Байгаль орчин, ХАА, геологийн албанд харьяалагдаж, органик тариалан эрхэлдэг түнш аж ахуйнуудад судалгааны ажил гүйцэтгэх, үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг түгээх чиг үүрэгтэйгээр ажилладаг. Нийдерзаксен муж улсад Герман улс дахь хамгийн анхны “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” 2002 онд байгуулагдсан бөгөөд органик тариалангийн гурван мэргэжлийн холбоо, дундын зөвлөх үйлчилгээний нэг нэгдэл тус төвийг хамтран эзэмшдэг. Төвийн үйл ажиллагаа органик тариаланчид, органик хүнс үйлдвэрлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд голчлон чиглэж байна. Түүнчлэн муж улсын түвшний бодлогын ба мэргэжлийн төрөл бүрийн зөвлөл, хороодод оролцож, хамтран ажилладаг. Зөвлөх үйлчилгээг органик тариаланд шилжихэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ, органик тариаланчдад чиглэсэн зөвлөх үйлчилгээ гэж ангилдаг.

Хөдөөг Хөгжүүлэх Европын Хөдөө Аж Ахуйн Сан (ELER)

Органик тариалан эрхлэгчдэд чиглэсэн ганцаарчилсан зөвлөх үйлчилгээнд „Хөдөөг Хөгжүүлэх Европын Хөдөө Аж Ахуйн Сан (ELER)” дэмжлэг үзүүлдэг. Дэмжлэгт хамрагдахын тулд зөвлөхүүд болон зөвлөх үйлчилгээний байгууллагууд тухайн муж улсынхаа ХАА-н яаманд итгэмжлэл авах хүсэлт ирүүлэх ба яамны зүгээс мэргэжлийн үр чадвар, үйлчилгээний үнэ хөлс зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн хүсэлтийг шийдвэрлэдэг. Сангаас дэмжлэг үзүүлэх одоогийн үе шат 2023 оноос эхэлсэн бөгөөд 2027 онд дуусгавар болно.

Органик тариаланд шилжихэд чиглэсэн ELER сангийн дэмжлэгтэй зөвлөх үйлчилгээ

Уламжлалт аргаар газар тариалан, ногооны аж ахуй эрхлэгчид органик тариаланд шилжих нь шинэ боломжуудын зэрэгцээ шинэ сорилтуудыг ч дагуулдаг тул эдгээр тариаланчдад шийдвэр гаргахынх нь өмнө мэргэжлийн зөвлөхүүд дэлгэрэнгүй зөвлөгөө өгч тусалдаг. Уг зөвлөх үйлчилгээ нь шилжилттэй холбоотой бүх асуудлыг хамарна. Ялангуяа органик тариалан эрхэлж эхэлснээр шинэ худалдан авагчид хайх шаардлага үүсэх тул худалдан авагчидтай холбож өгөх нь маш чухал. Нийдерзаксен муж улсад органик тариаланд шилжихэд чиглэсэн зөвлөх үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.



Органик тариаланчдад чиглэсэн ELER сангийн дэмжлэгтэй зөвлөх үйлчилгээ

ELER сангийн дэмжлэг бүхий органик тариалангийн зөвлөн үйлчилгээг муж улсууд харилцан адилгүй зохион байгуулдаг. Жишээлбэл Шлесвиг-Холштайн муж улсад ХАА-н танхим, органик тариалангийн мэргэжлийн холбоод зэрэг төрөл бүрийн байгууллагуудад харъяалагддаг 40 зөвлөх хамтран “Органик тариалангийн түршилт судалгаа, зөвлөх үйлчилгээний ÖKORING нийгэмлэг” байгуулж, уг нэгдлийг тус муж улсын ХАА-н яамнаас итгэмжилсэн байдаг. ÖKORING нийгэмлэгээс 5-13 цагийн багтаамжтай стандартчилсан модулиудын дагуу тариаланчдад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үйлчилгээний үнэ хөлсийг муж улс 100% хариуцдаг.

Баден-Вюрттемберг муж улсад чиг үүргээрээ ялгаатай ХАА-н зөвлөх үйлчилгээний 7 байгууллага нэгдэж “Баден-Вюрттембергийн органик тариалангийн зөвлөх үйлчилгээний OEBBW нэгдэл” байгуулжээ. Уг нийгэмлэгийн нэг гишүүн болох “Органик хүнсний ногооны зөвлөх үйлчилгээний нийгэмлэг” 30 жилийн ажлын туршлагатай. Тус нийгэмлэгт органик ногооны аж ахуйн эрхлэгчид нэгдсэн бөгөөд нийгэмлэгийн зүгээс гишүүдээ анхан шатны зөвлөх үйлчилгээг үнэгүй үзүүлж, утсаар зөвлөгөө өгдөг. Түүнчлэн мэдлэг түгээх, мэргэжил дээшлүүлэх зорилгоор бүлгийн уулзалт, сургалт, сургалтын аялал зэрэг зэрэг хэмжээг зохион байгуулж, эдгээр арга хэмжээнүүдийнхээ талаарх мэдээллийг факс, “Органик ногоочдын мэдээллийн хуудас” зэрэг хэрэгслүүдээр гишүүддээ хүргэдэг. Нийдерзаксен муж улсын “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” органик тариалангийн мэргэжлийн 3 холбоодтой хамтран органик тариаланчдад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Зөвлөх үйлчилгээний үнэ хөлсийн 80 хувийг муж улс хариуцдаг. ELER сангийн дэмжлэгтэйгээр зөвлөх үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийг зөвлөх үйлчилгээний 33 байгууллага авсан бөгөөд тус тусдаа хараат бус байдлаар ажилладаг.

Нийдерзаксен муж улсын органик хүнсний ногооны тариалангийн зөвлөх үйлчилгээ

Нийдерзаксен муж улсад дунджаар 0.4 га талбайтай 80 гаруй органик ногооны аж ахуй эрхлэгчид, мөн 200 гаруй органик газар тариалан эрхлэгчид ажиллаж байна. “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв”, органик тариалангийн мэргэжлийн гурван холбоодын хамтран байгуулсан “Органик тариалангийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний алба”-нд одоогоор тариалангийн 3 зөвлөх ажиллаж буй бөгөөд эдгээрийн хоёр нь ногооны аж ахуй эрхлэгчдэд, нэг нь газар тариалан эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Ногооны аж ахуй эрхлэгчдийн зөвлөх үйлчилгээний хэрэгцээ газар тариалан эрхлэгчдийнхээс ялгаатай тул энэ хоёр салбарыг салгаж авч үздэг. Органик газар тариалан эрхлэгчид шар лууван, сонгино, хүрэн манжин зэрэг цөөн таримлын эрчимжсэн тариалан эрхэлдэг бол ногооны аж ахуй эрхлэгчид олон төрөл зүйлийн хүнсний ногоо тариалж, зарим нь хүлэмжийн аж ахуй эрхэлдэг. “Органик тариалангийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний алба” нь түүнчлэн “вэбсайт бүтээх”, “чанарын баталгаажуулалт, ХААЗД, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), ханган нийлүүлэгчдийн аудит”, “Эдийн засаг, аж ахуйн өв залгамжлал”, “Бизнесийн коучинг”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар тариалан”, “Хэрэглэгчидтэй хамтарсан газар тариалан”, “Зөгийн аж ахуй” зэрэг сэдвүүдээр дагнасан зөвлөхүүдтэй бөгөөд эдгээр сэдвүүдийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд мөн л ELER сангаас дэмжлэг хүртдэг.

Нийдерзаксен муж улсын “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв”-ийн зөвлөхүүд мөн тус төвөөс хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдэд оролцож, талбайн өдөрлөг, “тариаланчдын талбайн сургууль” зэрэг сургалтын арга хэмжээнүүдээр мэргэжлийн мэдлэг, туршлагаа хуваалцдаг.

Байгууллагын харъяалалтай зөвлөхүүдийн зэрэгцээ бие даан ажилладаг хараат бус зөвлөхүүд ч органик тариаланчдад тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхэд нь тусалж, хамтран ажилладаг. Жишээ нь Нийдерзаксен муж улсад хүнсний ногооны тариалангийн ашигтай шавьжны сэдвээр дагнасан, мөн жижиглэн худалдаанд зориулан “саванд ургаастай органик ногоо” бэлтгэх, борлуулах



чиглэлээр төрөлжсөн зөвлөхүүд бий. Герман улсын органик тариалангийн бүх зөвлөхүүд хоорондоо нягт холбоотой, бие биенээ харилцан дэмжиж ажилладаг.

Газар тариалангийн салбарт бизнес эрхэлдэг, жишээ нь органик үр, ХАА-н техник, хүлэмж үйлдвэрлэдэг ААН-үүд ч мөн органик тариалангийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн органик тариалангийн мэргэжлийн холбоодод гишүүнээр элссэн тариаланчдад холбооных нь зүгээс төрөл бүрийн сэдвийг хамарсан зөвлөх үйлчилгээний багцуудыг санал болгодог.

Органик ХАА-н загвар бүс нутгууд

Германы 16 муж улс тус бүр органик тариаланг хөгжүүлэх хөтөлбөр (Органик ХАА-г хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр) баталж, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт тодорхой ямар санаачлагуудыг хэрхэн дэмжих талаар нарийвчлан тусгасан байдаг. Нийдерзаксен муж улсын хувьд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг үндсэн чиглэл нь органик ХАА-н загвар бүс нутгуудыг бий болгох, дэмжих явдал юм. Муж улс дахь засаг захиргааны нэгжүүд дангаар болон хамтарч Органик ХАА-н загвар бүс нутаг болох хүсэлт ирүүлэх боломжтой ба хүсэлтэд тус бүс нутагт органик газар тариаланг хэрхэн хөгжүүлэх, бүс нутагт үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүнийг хэрхэн борлуулах төлөвлөгөөг хавсаргана. Хүсэлтийг батламжилсан тохиолдолд төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд муж улсаас санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Зөвлөмж

Герман улс, Нийдерзаксен муж улсын туршлагад үндэслэн Нийдерзаксен муж улсын “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв”-өөс Монгол оронд органик тариаланг хөгжүүлэх талаар дараах зөвлөмжийг санал болгож байна.

Олон улсад мөрдөгдөж буй органик тариалангийн стандартуудад нийцүүлэн Монгол улсад мөрдөх органик хүнс, ХАА-н үйлдвэрлэлийн стандартыг бий болгож, мөрдүүлэх

Органик хүнсний анхан шатны ба боловсруулах үйлдвэрлэлд мөрдөх стандартыг боловсруулахдаа Европын Холбооны “Органик хүнсний тухай журам” зэрэг олон улсад бэлээхэн мөрдөгдөж буй стандартад нийцүүлэх нь зүйтэй. Ингэснээр органик бүтээгдэхүүнийг харилцан хүлээн зөвшөөрөхөд дөхөм болж, импорт, экспортод саад учрах эрсдэлээс сэргийлэх боломжтой.

Нэгдсэн нэг шошго нэвтрүүлэх

Органик бүтээгдэхүүнийг тэмдэглэх нэг л шошго байвал хэрэглэгчдэд ойлгомжтой болно. Герман улсад органик бүтээгдэхүүнүүдэд ЕХ, Германы засгийн газар, органик тариалангийн мэргэжлийн холбоод, худалдааны байгууллагуудын гаргасан хэт төрлийн шошго, лац, лого хэрэглэж буй нь төөрөгдөл үүсгэж, ялгаж салгахад төвөгтэй байгааг хэрэглэгчид шүүмжлэх хандлага ажиглагддаг.

Органик тариаланчдын холбоо байгуулах

Органик ногооны аж ахуй, органик газар тариалан эрхлэгчдийн эрх ашгийг нийтэд нь төлөөлөхүйц нөлөө бүхий нэг л холбоо байгуулах нь зүйтэй.

Органик тариаланг дэмжих санхүүгийн хөшүүргүүдийг бий болгох

Органик тариаланг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг шаардагдана. Органик тариалан эрхэлж буй талбайд урамшуулал ногдуулах, агуулах зоорь, ногоо угаах, савлах тоног төхөөрөмж худалдан авахад хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх зэрэг санхүүгийн хөшүүргүүдийг нэвтрүүлж болно.



Эрэлтийг нэмэгдүүлэх

Органик бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх тусам органик тариалангийн цар хүрээг тэлэх боломжтой болно. Одоо байгаа хүнсний ногооны борлуулалтын бүтэц, сувгуудад тулгуурлан органик бүтээгдэхүүн борлуулах бүтцийг бий болгох нь зүйтэй.

Үлгэр дуурайл үзүүлэх

Органик хүнс үйлдвэрлэх, хэрэглэхэд тариаланчид, хэрэглэгчдийг уриалахын тулд төр өөрөө үлгэр дуурайл үзүүлэх нь чухал. Жишээ нь төрийн өмчийн тариалангийн талбай, аж ахуйнуудад органик тариалан эрхлэх замаар үлгэрлэж болно.

Зөвлөх үйлчилгээг хараат бус байдлаар зохион байгуулах

Органик тариалангийн зөвлөх үйлчилгээ хөндлөнгийн ашиг сонирхлоос ангид байх учиртай. Мэргэжлийн холбоодод хариуцуулж болохгүй.

Органик тариаланд шилжихэд чиглэсэн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх

Уламжлалт технологитой тариалангаас органик тариаланд шилжихэд нилээд олон асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх шаардлага тулгарна. Химийн болон синтетик ургамал хамгааллын бэлдмэл, эрдэс азотын бордоогүйгээр тариалан эрхлэхэд амаргүй, мэргэжлийн үр чадвар ихээхэн шаарддаг. Тариаланчдад мэргэжлийн туслалцаа үзүүлэх бололцоог хангахын тулд органик тариаланд шилжихэд чиглэсэн зөвлөх үйлчилгээнд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

Зөвлөх үйлчилгээг чадавхжуулах

Зөвхөн тариаланчид мөнгө төлөхгүйгээр зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэхийн тулд зөвлөх үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэж ойлгож болохгүй. Төрөөс дэмжлэг хүртсэн зөвлөхүүд тариаланчдад үнэхээр хүрч ажилладаг, мэдлэг, мэргэжлээ тогтмол дээшлүүлдэг байх хариуцлагын тогтолцоог бий болгох нь чухал. Зөвлөхүүдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр мэргэжлийн мэдлэгээс гадна зөвлөх үйлчилгээний арга зүй, дидактикийн үр чадвар олгоход чиглэх учиртай.

Зөвлөх үйлчилгээг түршилт судалгааны ажилд уялдуулах

Үйлдвэрлэлийн нөхцөлд хийгдэх түршилт судалгааны ажлуудад зөвлөхүүдийг оролцуулах замаар зөвлөх үйлчилгээг шинэ мэдлэг, мэдээллээр баяжуулах, нөгөө талаар зөвлөхүүдийн практик туршлагыг судалгааны ажилд ашиглах боломж бүрдэнэ.

Урт хугацаанд тогтвортой дэмжлэг үзүүлэх

Органик тариаланг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нилээд хугацаа орох бөгөөд энэ хугацаанд шаардагдах санхүүжилтийг баталгаажуулах шаардлагатай. Ургамлын селекциэр жишээ авахад таримлын сортод тавих шаардлага нь органик тариалан, уламжлалт технологитой тариалангийн хооронд зөрүүтэй тул органик тариаланд нийцсэн шинэ сортуудыг бий болгох ажлыг тусад нь зохион байгуулах, үүнд шаардагдах урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох нь зүйтэй.

Оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагааг хангах

Органик тариаланг хөгжүүлэхэд урт удаан хугацаа, төрөл бүрийн сорилт бэрхшээлийг даван түүлах шаардлагатай тул оролцогч талуудыг аль болох хооронд нь холбож, харилцаа, хамтын ажиллагааг



хөгжүүлэх нь чухал. Энэ үүргийг “Органик тариалангийн сургалт, мэдээллийн төв” хариуцах боломжтой.

Эх сурвалж, дэлгэрүүлж унших материал

Органик тариалангийн үндэс

<https://www.thuenen.de/de/themenfelder/oekologischer-landbau/grundlagen-der-oekologischen-landwirtschaft>

<https://www.bmel.de/SharedDocs/Downloads/DE/Broschueren/OekolandbauDeutschland.html>

Органик тариалангийн түүх

<http://orgprints.org/00001110/>

Европ

Органик хүнс, органик ХАА-н талаарх эрх зүйн зохицуулалтууд

<https://www.boelw.de/themen/eu-oeko-verordnung/>

<https://www.oekolandbau.de/service/rechtsgrundlagen/die-neue-eu-oeko-verordnung/>

Европын орнууд дахь органик тариалан - Өнөөгийн байдал, хөгжлийн чиг чандлага

<https://orgprints.org/id/eprint/25672/>

Герман улсын органик тариалангийн талаарх тайлан, төлөвлөгөө

ХАА-н бодлогын хэрэгжилтийн тайлан 2023:

<https://www.bmel.de/SharedDocs/Downloads/DE/Broschueren/agrarbericht-2023.html>

Органик ХАА, хүнс үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги 2030

<https://www.bmel.de/SharedDocs/Downloads/DE/Broschueren/bio-strategie-2030.html>

Органик тариалангийн ирээдүйн талаар баримтлах стратеги

https://www.bmel.de/SharedDocs/Downloads/DE/Broschueren/ZukunftsstrategieOekologischerLandbau2019.pdf?__blob=publicationFile&v=5

Герман улсын органик тариалангийн талаарх тоон мэдээ

<https://www.oekolandbau.de/service/zahlen-daten-fakten/oeko-flaeche-und-anzahl-oeko-betriebe-in-deutschland/>

Герман улсын органик хүнсний ногооны үйлдвэрлэл

<https://www.destatis.de/DE/Themen/Branchen-Unternehmen/Landwirtschaft-Forstwirtschaft-Fischerei/Obst-Gemuese-Gartenbau/Tabellen/oekologisches-gemuese.html>

Муж улсуудын Органик ХАА-г хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрүүд

<https://www.oekolandbau.de/bundeslaender/>

Төрөөс үзүүлэх дэмжлэг

Органик тариаланд төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаарх тариаланчдын байр суурь

<https://www.thuenen.de/de/institutsuebergreifende-projekte/foerderung-des-oekologischen-landbaus-aus-betrieblicher-sicht>

Органик тариаланд үзүүлж буй дэмжлэг Германы муж улс түс бүрээр

<https://www.oekolandbau.de/landwirtschaft/betrieb/oeko-foerderung/foerdersaetze-der-bundeslaender/>

Органик тариаланг дэмжих Холбооны хөтөлбөр

<https://www.bundesprogramm.de/>

Зах зээлийн мэдээлэл

<https://www.ami-informiert.de/ami-maerkte/maerkte/ami-maerkte-oekolandbau/meldungen>

**Харилцаа, хамтын ажиллагаа**

Органик хүнсний ногооны салбарын оролцогч талуудын хамтын бүтэц, зохион байгуулалт

<https://orgprints.org/id/eprint/11030/>

Судалгаа, зөвлөх үйлчилгээ

Органик ХАА эрхлэгчдэд чиглэсэн зөвлөх үйлчилгээ

<https://www.hnee.de/boewed>

Төлөв байдлын тойм

Германы органик хүнс, ХАА-н салбарын өнөөгийн төлөв

<https://www.thuenen.de/de/themenfelder/oekologischer-landbau/aktuelle-trends-der-deutschen-oekobranche>

Органик хүнсний ногооны зах зээлийн төлөв

<https://www.oekolandbau.de/landwirtschaft/biomarkt/bio-markt-in-deutschland/wie-entwickelt-sich-der-markt-fuer-bio-gemuese/>

Орлого

Органик тариалан эрхлэгчдийн орлогын өөрчлөлт

<https://www.thuenen.de/de/themenfelder/oekologischer-landbau/aktuelle-trends-der-deutschen-oekobranche/einkommensentwicklung-im-oekolandbau>

Герман улс дахь Органик тариалангийн сургалт, мэдээллийн төвүүд, Жишээ:

<https://www.lfl.bayern.de/iab/ueberuns/037015/index.php>

<https://www.landwirtschaft.sachsen.de/kompetenzzentrum-oekologischer-landbau.html>

<https://www.oeko-komp.de/>

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Каролин Грийсхоп

Нийдерзаксен муж улсын органик тариалангийн сургалт, мэдээллийн төв ХХК-ийн гүйцэтгэх захирал

Имэйл: info@oeko-komp.de